

# ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.10.06

## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- Монголбанк 9-р сард 2.09 тонн үнэт метал худалдан авлаа
- 2026 онд төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3–5% орчим сулрах магадлалтай
- Зуун мод молибден-зэсийн ордын нөөц таамаглалаас ихэслээ
- ERDN, GLMT хувьцаанууд арилжааны идэвхээрээ тэргүүлж байна

## МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.4%	1.93%	25.47%
MSE A	-0.1%	7.58%	20.27%
MSE B	-2%	0.2%	34.89%

2025/09/29 – 2025/10/03

## Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
ERDN	1,000,673,640.00
AHH	816,611,416.00
GLMT	418,872,200.00
KHAN	288,064,026.00
MSE	117,356,805.55

2025/09/29 – 2025/10/03

## Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
ERDN	24,520.00	22.60%
BOE	3,795.00	15.00%
JLT	67.27	14.99%
AOI	1,897.00	14.97%
NEH	20.02	10.30%

2025/09/29 – 2025/10/03

2025 он 10-р сарын 06

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

13,226

ТОП-20 индекс

49,254

MSE A

19,127

MSE B

14,342

## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - II улирал

Инфляц

8.8%

2025-08 сар

ГВУН(сая\$)

5,874.52

2025-08 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын

өгөөж

6.6%

USD/MNT

3,594.00

2025-10-05

 Эдийн засгийн мэдээлэл

## МОНГОЛБАНК 9-Р САРД 2.09 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА


2025 оны 9 дүгээр сарын байдлаар Монголбанк нийт 2,094.7 кг алт, мөнгөн металл худалдан авсан нь, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.5 % буурсан үзүүлэлт болж байна. Энэхүү худалдан авалт нь тухайн оны эхээрээ эхэлсэн оны эхнээс өссөн дүнгээр 9.8 тонн болоод байгаа нь өмнөх оны амжилттай харьцуулахад сул гүйцэтгэл илэрхийлж байна.

Алтны ханшийн хувьд дэлхийн зах зээл дээр үнэ тогтмол өсөх хандлагатай байгаа үед Монголбанкны худалдан авалт буурах нь сонирхол татаж байна. Энэ байдал удаан үргэлжилбэл валютын нөөц бүрдүүлэх, алтны стратегийн нөөц нэмэгдүүлэх зорилгод саад болж магадгүй тул бодлогоор уялдуулах шаардлага үүсч магадлгүй юм.

## ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3–5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



## Валютын ханшид нөлөөлөх гадаад эрсдэлүүд

- БНХАУ-ын үл хөдлөх салбарын хүндрэл болон тарифын гэнэтийн шийдвэрүүдээс шалтгаалан гангийн эрэлт буурч байна.
- Коксжих нүүрсний эрэлт 2026 онд 1.5% буурах хүлээлттэй ба эрэлтээ давсан их овоолго үүссэн байгаа нь үнэ өнөөгийн түвшинд эсвэл буурч магадгүй.
- Том гүрнүүдийн худалдааны зөрчил ширүүсч, Хятадын эдийн засаг болон эрдэсийн үнэ муудвал төлбөрийн тэнцэлд дарамт үүснэ. Энэ үед дотоод эх үүсвэрээр томоохон төслүүдийг санхүүжүүлэх нь алдагдлыг тэлж, эдийн засгийн хүндрэл гүнзгийрэх эрсдэлтэй.



## Зах зээлийн мэдээлэл

### ТОП-20 ИНДЕКС 9-Р САРД 2 ГАРУЙ ХУВИАР ӨСЛӨӨ

График 2. ТОП-20 индексийн ханшийн өөрчлөлт



ТОП-20 индекс 2025 он гарснаар 6.23 хувиар унаад байна. Компаниудын орлого эхний хагас жилд өссөн ч гэсэн цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байлаа. Ханш 46,300 түвшин рүү үргэлжлэн унах магадлал өндөр бөгөөд 46,300 хүчтэй дэмжлэгийн бүс болж байна. Энэ оны сүүлийн улиралд индекс хүчтэй өсөх магадлалай.

### ЗУУН МОД МОЛИБДЕН-ЗЭСИЙН ОРДЫН ШИНЭЧИЛСЭН НӨӨЦИЙН ТООЦООЛОЛ

- Молибденийн баттай болон бодитой нөөц 22% өсөж 333 сая фунт, боломжтой нөөц 95% өсөж 300 сая фунт болсон.
- Зэсийн баттай болон бодитой нөөц 16% өсөж 384 сая фунт, боломжтой нөөц 75% өсөж 350 сая фунт-д хүрчээ.

Ингэснээр 2025 оны байдлаар Зуун Модын нийт баттай, бодитой нөөц 271.1 сая тонн хүдэрт агуулагдах 333.5 сая фунт молибден, 384.2 сая фунт зэс болсон нь 2011 оны тооцооллоос ойролцоогоор 50%-ийн өсөлт үзүүлж байна. Энэхүү орд нь Баянхөндий алтны уурхайгаас 35 км, БНХАУ-ын хилээс 180 км зайд, дэд бүтэц ид хөгжиж буй бүс нутагт байрладаг бөгөөд Ази тивийн хамгийн том, хөгжүүлэлт хийгдээгүй молибден-зэсийн ордуудын нэг гэж тооцогдож байна.


2025 оны 4-р улиралд төлөвлөж буй өрөмдлөгийн хөтөлбөрөөр зэсийн шинэ бүсийг шалгаж, нөөцийг улам нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Мөн төслийн хүрээнд боловсруулалт, дэд бүтэц, зах зээлийн судалгааг зэрэг гүйцэтгэж байгаа бөгөөд Зуун Мод ордын геологийн бүтэц, стратегийн байршил, өсөж буй молибденийн эрэлт нь төслийн урт хугацааны хөгжлийн өндөр чадавхийг илтгэж байна.

## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.